ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2025/118/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн Стандарт дүгнэлт аудит ХХК
аудитор: Б.Наранцэцэг
Утас: 99569960 Цахим хаяг: info@sda-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.22 № 187

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.АРИУНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс 1,097,665.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 232,864.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,100.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,358.7 мянган төгрөг, нийт 1,332,988.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,237,878.5 мянган төгрөг зарцуулан, 770.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансандаа 172,328.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар 30,755.2 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрч, 25,850.2 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2,156.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,749.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232502187

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 76 арга хэмжээ тусгагдаж, 96 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 186,034,051.88 | 341,986,106.16 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 77,231,916.45 | 172,328,285.79 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 77,231,916.45 | 172,328,285.79 |
| 3121 | Төгрөг | 77,231,916.45 | 172,328,285.79 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 77,231,916.45 | 172,328,285.79 |
| 33 | АВЛАГА | 395,648.59 | 395,648.59 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 395,648.59 | 395,648.59 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 50,000.00 | 50,000.00 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 50,000.00 | 50,000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 50,000.00 | 50,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 108,356,486.84 | 169,212,171.78 |
| 351 | Түүхий эд материал | 4,666,420.00 | 2,116,660.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,666,420.00 | 2,116,660.00 |
| 354 | Хангамжийн материал | 103,690,066.84 | 167,095,511.78 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,754,500.00 | 2,477,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 712,780.00 | 7,270,780.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,001,000.00 | 11,841,950.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,122,300.00 | 3,812,990.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 90,099,486.84 | 141,692,291.78 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 435,701,297.95 | 5,471,340,357.20 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 435,701,297.95 | 5,471,340,357.20 |
| 392 | Биет хөрөнгө | 427,483,297.95 | 5,463,122,357.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 392,248,953.26 | 5,406,608,953.26 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (60,165,237.04) | (129,514,939.81) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 241,754,334.90 | 280,416,878.39 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (156,347,854.54) | (161,425,965.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,585,911.41 | 110,541,172.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (45,427,085.37) | (46,008,142.23) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,974,000.00 | 3,974,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,489,562.57) | (2,819,437.59) |
| 39217 | Ном | 1,349,837.90 | 1,349,837.90 |
| 393 | Биет бус хөрөнгө | 8,218,000.00 | 8,218,000.00 |
| 39301 | Програм хангамж | 360,000.00 | 360,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (360,000.00) | (360,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,218,000.00 | 8,218,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 621,735,349.83 | 5,813,326,463.36 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 56,640.00 | 5,886,229.04 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 56,640.00 | 5,886,229.04 |
| 413 | Өглөг | 56,640.00 | 5,886,229.04 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,754,089.00 |
| 4136 | Бусад өглөг | 56,640.00 | 132,140.04 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 56,640.00 | 132,140.04 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 621,678,709.83 | 5,807,440,234.32 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 621,678,709.83 | 5,807,440,234.32 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 456,998,392.50 | 456,998,392.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 456,998,392.50 | 456,998,392.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 149,474,300.95 | 5,335,235,825.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 149,474,300.95 | 149,474,300.95 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 5,185,761,524.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 15,206,016.38 | 15,206,016.38 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 621,735,349.83 | 5,813,326,463.36 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **897,067,500.00** | **6,471,276,836.28** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **640,400.00** | **5,140,746,636.28** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 640,400.00 | 5,140,746,636.28 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 640,400.00 | 2,458,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 640,400.00 | 1,358,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,100,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | | 5,102,933,290.94 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал | | 35,354,645.34 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **896,427,100.00** | **1,330,530,200.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 694,594,100.00 | 1,097,665,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 694,594,100.00 | 1,097,665,300.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 201,833,000.00 | 232,864,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 201,833,000.00 | 232,864,900.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **865,821,473.16** | **1,285,515,311.79** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **865,821,473.16** | **1,285,515,311.79** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 735,224,151.89 | 1,260,320,567.62 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 492,757,912.36 | 778,665,163.50 |
| 210101 | Үндсэн цалин | 340,720,309.87 | 465,135,651.64 |
| 210102 | Нэмэгдэл | 127,059,400.22 | 268,136,816.46 |
| 210104 | Урамшуулал | 24,978,202.27 | 45,392,695.40 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,909,735.61 | 110,867,537.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,651,918.34 | 81,223,644.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,697,091.80 | 7,224,639.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,098,125.70 | 3,837,067.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 962,762.21 | 3,340,502.23 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,499,837.56 | 15,241,683.61 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 87,185,498.73 | 197,694,765.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,805,724.73 | 13,450,955.83 |
| 210302 | Түлш, халаалт | 75,379,774.00 | 183,431,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 812,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 17,852,663.00 | 5,026,840.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,001,600.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,375,460.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,440,000.00 | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,035,603.00 | 5,026,840.40 |
| 2105 | **Норматив зардал** | 16,301,050.00 | 18,329,020.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,301,050.00 | 18,329,020.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,418,000.00 | 22,384,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,418,000.00 | 22,384,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,562,900.00 | 5,243,423.60 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,562,900.00 | 5,243,423.60 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,236,392.19 | 122,109,816.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,328,720.00 | 34,523,272.53 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,501,760.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 45,405,912.19 | 87,586,544.40 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 130,597,321.27 | 25,194,744.17 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 24,637,520.00 | 24,424,310.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,371,720.00 | 18,101,630.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,265,800.00 | 6,322,680.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 105,959,801.27 | 770,434.17 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 105,959,801.27 | 770,434.17 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **31,246,026.84** | **5,185,761,524.49** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **31,246,026.84** | **5,185,761,524.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **897,067,500.00** | **1,332,988,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **640,400.00** | **2,458,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 640,400.00 | 2,458,700.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 640,400.00 | 2,458,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 640,400.00 | 1,358,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **896,427,100.00** | **1,330,530,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 694,594,100.00 | 1,097,665,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 694,594,100.00 | 1,097,665,300.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 201,833,000.00 | 232,864,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 201,833,000.00 | 232,864,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **827,089,167.97** | **1,237,892,530.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **827,089,167.97** | **1,237,892,530.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **694,246,416.70** | **1,212,371,540.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 492,231,713.36 | 784,179,356.82 |
| 210101 | Үндсэн цалин | 341,906,309.87 | 477,466,382.12 |
| 210102 | Нэмэгдэл | 125,347,201.22 | 265,119,668.38 |
| 210104 | Урамшуулал | 24,978,202.27 | 41,593,306.32 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 61,909,734.61 | 98,896,799.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,325,415.15 | 68,620,318.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,023,594.99 | 7,681,911.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,098,125.70 | 3,828,409.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 950,850.15 | 3,688,097.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,511,748.62 | 15,078,062.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 86,944,198.73 | 197,694,765.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,805,724.73 | 13,450,955.83 |
| 210302 | Түлш, халаалт | 75,138,474.00 | 183,431,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 812,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,538,350.00 | 18,002,160.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,538,350.00 | 18,002,160.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,929,000.00 | 34,399,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,929,000.00 | 34,399,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,706,900.00 | 11,579,982.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,022,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,706,900.00 | 9,557,282.80 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,986,520.00 | 67,618,776.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,926,480.00 | 63,348,776.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,060,040.00 | 4,270,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **132,842,751.27** | **25,520,990.17** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,882,950.00 | 24,750,556.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,920,950.00 | 17,725,420.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,962,000.00 | 7,025,136.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 105,959,801.27 | 770,434.17 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 105,959,801.27 | 770,434.17 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **69,978,332.03** | **95,096,369.34** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 69,978,332.03 | 95,096,369.34 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 77,231,916.45 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 77,231,916.45 | 172,328,285.79 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **456,998,392.50** | **15,206,016.38** | **149,474,300.95** | 621,678,709.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 5,185,761,524.49 | 5,185,761,524.49 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **456,998,392.50** | **15,206,016.38** | **5,335,235,825.44** | 5,807,440,234.32 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1.0 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,411,118,700.00** | **1,237,122,096.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,411,118,700.00 | 1,237,122,096.49 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,383,767,300.00 | 1,212,371,540.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 929,697,400.00 | 784,179,356.82 |
| 210101 | Үндсэн цалин | 595,598,400.00 | 477,466,382.12 |
| 210102 | Нэмэгдэл | 303,925,300.00 | 265,119,668.38 |
| 210104 | Урамшуулал | 30,173,700.00 | 41,593,306.32 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 116,212,200.00 | 98,896,799.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,024,300.00 | 68,620,318.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,296,900.00 | 7,681,911.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,648,500.00 | 3,828,409.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,648,500.00 | 3,688,097.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,594,000.00 | 15,078,062.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 200,864,900.00 | 197,694,765.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,425,000.00 | 13,450,955.83 |
| 210302 | Түлш, халаалт | 183,439,900.00 | 183,431,810.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,000,000.00 | 812,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,463,200.00 | 18,002,160.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,463,200.00 | 18,002,160.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 32,000,000.00 | 34,399,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,000,000.00 | 34,399,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,641,100.00 | 11,579,982.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,022,700.00 | 2,022,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,618,400.00 | 9,557,282.80 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 68,888,500.00 | 67,618,776.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,612,000.00 | 63,348,776.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,276,500.00 | 4,270,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27,351,400.00 | 24,750,556.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,351,400.00 | 24,750,556.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,326,200.00 | 17,725,420.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,025,200.00 | 7,025,136.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,411,118,700.00** | **1,332,218,465.83** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,097,665,300.00 | 1,097,665,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,097,665,300.00 | 1,097,665,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 232,864,900.00 | 232,094,465.83 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 232,864,900.00 | 232,094,465.83 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 80,588,500.00 | 2,458,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,358,700.00 | 1,358,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 1,100,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 77,229,800.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **77,231,916.45** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **172,328,285.79** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | - | 29.00 |
| 620001 | Удирдах ажилтан | - | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | 18.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | 10.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 25,850.2 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг анхан шатны баримтаас 19,325.7 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 65.2 сая төгрөгөөр зөрүүтэй, төсөвт төвлөрүүлсэн 770.4 мянган төгрөгийг тохируулаагүй байна.
- Ажиллагсдаас суутгасан 5,754.1 мянган төгрөгийн ХХОАТ-г дутуу шилжүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Аудитаар 4,905.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,156.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,749.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

### 3.1Төлбөрийн акт

1. Хүнсний материалын үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 2,156.0 мянган төгрөгийн 196 кг мах дутагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг зөрчсөн байна.

### 3.2 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас ажил олгогчийн шимтгэлийн 2,303.3 мянган төгрөгийг төлж, эдийн засгийн ангилал зөрчиж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн байна.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан ХХОАТатвар, НДШ-ийн 445.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-г зөрчсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Байхгүй.

## 4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХХОАТ-ыг дутуу шилжүүлж, өглөгөөр бүртгээгүй. | 1 | 5,754.1 | 1 | 5,754.1 | | | 1 | 5,754.1 | | | | |
| Цалингийн зардлыг анхан шатны баримтаас 19,325.7 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн. | 1 | 19,325.7 | | | 1 | 19,325.7 | 1 | 19,325.7 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд 770.4 мянган төгрөгийг тохируулах бичилт хийгээгүй байна. | 1 | 770.4 | 1 | 770.4 | | | 1 | 770.4 | | | | |
| **Дүн** | 3 | 25,850.2 | 2 | 6,524.5 | 1 | 19,325.7 | 3 | 25,850.2 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт-ны тоо | Тоо | Дүн |
| Зориулалт бус зарцуулсан | 1 | 2,303.3 | | | 1 | 2,303.3 | | | | | | |
| Бараа материал дутагдсан | 1 | 2,156.0 | 1 | 2,156.0 | | | | | | | | |
| Авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй | 1 | 445.6 | | | 1 | 445.6 | | | | | | |
| **Дүн** | **3** | **4,904.9** | **1** | **2,156.0** | **2** | **2,748.9** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><td rowspan="3">Зөрчлийн товч утга</td><td colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</td><td colspan="6">Үүнээс</td></tr>
<tr><td colspan="2">Төлбөрийн акт</td><td colspan="2">Албан шаардлага</td><td colspan="2">Зөвлөмж</td></tr>
<tr><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td><td>Тоо</td><td>Дүн</td></tr>
<tr><td colspan="9">Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="9">Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 19 өдөр Дугаар 56-ХЭА-2025/118/НА-СТА-ТШЗ Чингис хот
17925043

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын ЕБС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний материалын үлдэгдэлд түүвэр тооллогыг хийхэд 196 кг буюу 2156.0 мянган төгрөгийн мах дутагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.7.-д " Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутагдсан махны үнэ 2,156.0 төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого"-ын 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 9 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөрөн сумын ЕБС-ын захирал М.Ариунаа, нягтлан бодогч Ц.Угантуяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Б.НАРАНЦЭЦЭГ

23350505С

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 20 Дугаар 80-ХЭА-2025/118/НА-СТА-ТШЗ Чингис хот
17925043

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн 2,303.3 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлж, эдийн засгийн ангилал зөрүүлэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал М.Ариунаа, нягтлан бодогч Ц.Угантуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

“СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ”
ХХК-ИЙН АУДИТОР Б.НАРАНЦЭЦЭГ

232504080

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас: 70562112

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 дугаар сарын 20 Дугаар 79-ХЭА-2025/118/НА-СТА-ТШ3 Чингис хот

17925043

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан татвар, шимтгэлийн 445.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д " авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирал М.Ариунаа, нягтлан бодогч Ц.Уугантуяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Б.НАРАНЦЭЦЭГ

232504079

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас: 70562112